



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/321

Булган сум

┌ Хагас жилийн мал тооллого явуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, в, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хагас жилийн мал тооллогыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. Тооллогыг товлосон хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Тооллогын үр дүнгээр сумын түвшинд нэгтгэлийг боловсруулж, малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр олгох тул бэлтгэл ажлыг сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу мэдээлэл цуглуулалтын чанар бодит байдалд анхаарч, тооллогын ажилд томилогдсон албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэн гарч болзошгүй алдаанаас урьдчилан сэргийлж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг тооллогын ажлын хэсгийн ахлагч (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

4. Хагас жилийн малын түүвэр судалгааны аргачлал, маягт заавар, арга зүйг нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явц, сан бүрдүүлэлт, үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллахыг Статистикийн хэлтсийн дарга (М.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

5. Хагас жилийн мал тооллогын дүнг 2024 оны 06 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



05 дугаар сарын 13-ны/ний өдрийн А/22 дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн хавсралт

2024 оны хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга: Д.Жаргалсайхан (Аймгийн Засаг даргын орлогч дарга)

Ажлын хэсгийн орлогч дарга: М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)

Гишүүд:
Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)
А.Нарантуяа (Статистикийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн)
Н.Булганбаяр (Статистикийн хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ц.Батчимэг (Статистикийн хэлтсийн Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн)